


**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2017 оны эхний 11 сарын байдлаар 6,458.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 7,439.3 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 980.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээний 34.7 хувьтай тэнцэж, төлөвлөснөөс 1,845.5 тэрбум төгрөгөөр буурч, төсвийн тэнцэл сайжирлаа.

**График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/**



2017 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,290.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 129.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсөв 181.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 27.7 хувь буюу 1,399.5 тэрбум төгрөгөөр өсч, харин нийт зарлага 3.8 хувь буюу 297.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 63.4 хувь буюу 1,696.9 тэрбум төгрөгөөр багассан үзүүлэлттэй гарлаа.

**Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр**

**Хүснэгт 1.**

	ӨО-ны мөн үеийн	/тэрбум төгрөг/			
		2017 оны эхний 11 дүгээр сар			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	632.6	586.3	-790.1	-134.8	1,376.3
Засгийн газрын бонд	1,512.2	574.1	1,001.0	174.4	-426.9
Засгийн газрын зээл	532.5	966.3	587.2	60.8	379.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	129.8	160.0	123.3	-30.2
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	529.2	0.0	-	529.2
Өмч хувьчлал	0.0	40.4	22.2	55.1	18.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,677.3</b>	<b>2,826.0</b>	<b>980.4</b>	<b>34.7</b>	<b>1,845.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

2017 оны эхний 11 сарын байдлаар гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 151.0 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 2,644.6 тэрбум төгрөг, богино хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 922.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, харин 622.3 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авчээ. Засгийн газрын 1,760.0 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 1,366.2 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод бондыг тус тус арилжаалж, мөн 3,463.1 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бонд шинээр гаргасан байна.

**2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого**

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 6,458.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 27.7 хувь буюу 1,399.5 тэрбум төгрөгөөр өссөн, мөн орлогын төлөвлөгөө 6.8 хувь буюу 411.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 6.1 хувь буюу 265.1 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 0.09 хувь буюу 2.0 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын төсөв 5.7 хувь буюу 101.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 1,290.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 220.9 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 263.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Нэгдсэн төсвийн орлогын 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар  
**Хүснэгт 2.** /тэрбум төгрөг/

Ангилал	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	6,595.0	7,075.2	4,904.7	5,239.0	2,131.9	2,133.9	1,789.0	1,890.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	237.5	295.3	237.5	295.3	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	309.6	321.0	309.6	321.0	0.0	0.0	0.0	0.0
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	6,047.9	6,458.9	4,357.6	4,622.7	2,131.9	2,133.9	1,789.0	1,890.1
<b>Татварын орлого</b>	5,165.1	5,626.2	3,286.3	3,627.3	833.8	845.9	1,250.6	1,351.8
Орлогын албан татвар	1,253.5	1,435.5	710.1	889.4	543.4	546.2	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	1,045.1	1,153.1	0.0	0.0	0.0	0.0	1,250.6	1,351.8
Хөрөнгийн албан татвар	97.7	102.8	0.0	0.0	97.7	102.8	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,363.9	1,479.0	1,363.9	1,479.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	437.6	460.6	437.6	460.6	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	11.4	11.6	11.4	11.6	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	449.8	455.5	449.8	455.5	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	506.1	528.2	313.5	331.3	192.6	196.9	0.0	0.0
<b>Татварын бус орлого</b>	882.8	832.7	1,071.3	995.4	1,298.1	1,288.0	538.3	538.3
Нийтлэг татварын бус орлого	809.9	786.4	665.2	654.7	144.7	131.7	0.0	0.0
Хөрөнгийн орлого	1.1	0.6	0.0	0.0	1.1	0.6	0.0	0.0
Тусламжийн орлого	71.7	45.7	252.5	213.4	0.2	3.7	538.3	538.3
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	153.6	127.3	1,152.1	1,152.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 87.1 хувийг татварын орлого, 12.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 27.5 хувь буюу 1,212.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 29.0 хувь буюу 187.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Татварын орлого 5,626.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 8.9 хувь буюу 461.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.**

Татварын орлогын 25.5 хувийг орлогын албан татвар, 26.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 20.5 хувийг нийгмийн даатгалын орлого, 8.2 хувийг онцгой албан татвар, 8.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 9.4 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/**




Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн орлогын албан татвар 14.5 хувь /182.0 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 8.4 хувь /115.1 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 10.3 хувь /108.0 тэрбум.төг/, онцгой албан татвар 5.2 хувь /22.9 тэрбум.төг/, бусад татвар 4.4 хувь /22.1 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 2.0 хувь /0.2 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны татварын орлого 1.3 хувь /5.7 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 5.2 хувь /5.0 тэрбум.төг/ -иар тус тус давж биелжээ.

Татварын орлого өмнөх оны мөн үеэс 1,212.5 тэрбум төгрөг буюу 27.5 хувиар өссөн байна. Онцгой албан татвар өмнөх оны мөн үеэс 125.2 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч орлогын албан татвар 531.0 тэрбум (58.7%), нэмэгдсэн өртгийн албан татвар 485.1 тэрбум (48.8%), гадаад үйл ажиллагааны орлого 159.7 тэрбум (54.0%), нийгмийн даатгалын орлого 119.0 тэрбум (11.5%), бусад татвар, төлбөр, хураамж 28.7 тэрбум (5.7%), хөрөнгийн албан татвар 12.3 тэрбум (13.5%) болон тусгай зориулалтын орлого 2.0 тэрбум төгрөг (21.0%)-өөр тус тус нэмэгдэж, татварын орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

**Татварын бус орлого 832.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 29.0 хувь буюу 187.1 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч тус орлогын төлөвлөгөө 50.1 тэрбум төгрөг буюу 5.7 хувиар дутуу биелсэн байна.**

Татварын бус орлогын төлөвлөгөө дутуу биелэхэд төсөвт байгууллагын өөрийн орлого 59.9 тэрбум, гадаад хандив, тусламжийн орлого 26.1 тэрбум, хувьцааны ногдол ашиг 1.5 тэрбум, навигагийн орлого 0.8 тэрбум, хөрөнгийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хүүгийн орлого 24.5 тэрбум, торгуулийн орлого 4.9 тэрбум, татварын бус бусад орлого 6.3 тэрбум болон газрын тосны орлого 2.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**График 4.** Татварын бус орлогын бүтэц /хувиар



Татварын бус орлогын 94.4 хувийг нийтлэг татварын бус орлого, 5.5 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна. Нийтлэг татварын бус орлогын 38.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.7 хувийг газрын тосны орлого, 16.5 хувийг навигацийн орлого, 4.9 хувийг торгуулийн орлого, 4.7 хувийг хүүгийн орлого болон 8.3 хувийг бусад орлого эзэлж байна.

*Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн дагуу 20 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 9 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол 11 нь 3.4-82.7 хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 14.0 хувь, Гаалийн ерөнхий газар 1.8 хувиар тус тус давуулан биелүүлжээ.*

2017 оны эхний 11 сард улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

**Хүснэгт 3.**

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Сангийн сайд</b>	<b>3,099,738.5</b>	<b>4,467,154.6</b>	<b>4,568,240.6</b>	<b>-101,085.9</b>	<b>102.3</b>
Татварын ерөнхий газар	1,223,984.0	2,206,701.7	2,514,859.6	-308,157.9	114.0
Гаалийн ерөнхий газар	1,379,352.7	1,703,849.6	1,735,011.6	-31,162.0	101.8
Сангийн яам	18,355.3	392,187.3	196,887.1	195,300.1	50.2
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	445,344.6	101,920.0	54,251.2	47,668.8	53.2
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	25,647.7	47,282.1	9,828.8	37,453.2	20.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	7,054.2	15,214.0	57,402.2	-42,188.2	377.3
<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>1,719.8</b>	<b>13,267.0</b>	<b>13,887.5</b>	<b>-620.5</b>	<b>104.7</b>
Гадаад тусламжийн орлогоос	1,719.8	13,267.0	13,887.5	-620.5	104.7

	санхүүжих					
<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>		<b>0.0</b>	<b>3,387.9</b>	<b>1,226.1</b>	<b>2,161.9</b>	<b>36.2</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	3,387.9	1,226.1	2,161.9	36.2
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>		<b>6,802.7</b>	<b>33,667.9</b>	<b>45,627.2</b>	<b>-11,959.4</b>	<b>135.5</b>
	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	1,310.0	1,863.6	1,442.8	420.7	77.4
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	2,304.9	16,091.1	26,942.3	-10,851.2	167.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,187.8	15,713.2	17,242.1	-1,528.9	109.7
<b>Монгол Улсын Шадар сайд</b>		<b>15,873.9</b>	<b>29,644.6</b>	<b>33,377.6</b>	<b>-3,733.0</b>	<b>112.6</b>
	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	2,069.2	2,189.3	3,573.2	-1,383.9	163.2
	Стандарт, хэмжил зүйн газар	2,630.9	2,448.1	2,651.3	-203.1	108.3
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,212.2	10,302.8	7,294.3	3,008.5	70.8
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	6,961.5	14,704.4	19,858.8	-5,154.4	135.1
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>		<b>37,794.6</b>	<b>112,070.1</b>	<b>108,226.0</b>	<b>3,844.1</b>	<b>96.6</b>
	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	21,655.8	17,061.8	17,441.8	-380.0	102.2
	Цагдаагийн ерөнхий газар	1,853.5	2,596.0	2,319.8	276.2	89.4
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	854.2	15,658.6	16,051.2	-392.6	102.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	13,431.2	76,753.7	72,413.2	4,340.6	94.3
<b>Гадаад харилцааны сайд</b>		<b>11,838.1</b>	<b>25,011.0</b>	<b>26,416.5</b>	<b>-1,405.5</b>	<b>105.6</b>
	Дипломат төлөөлөгчийн газрууд	11,239.0	17,906.9	21,791.2	-3,884.3	121.7
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	599.1	7,104.2	4,625.3	2,478.8	65.1
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>		<b>114,868.2</b>	<b>144,376.9</b>	<b>171,046.1</b>	<b>-26,669.2</b>	<b>118.5</b>
	Иргэний нисэхийн ерөнхий газар	108,844.4	130,487.1	129,677.5	809.6	99.4
	Зам, тээврийн хөгжлийн яам	150.0	174.0	190.0	-16.0	109.2
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,198.5	5,006.3	7,175.1	-2,168.9	143.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,675.2	8,709.6	34,003.4	-25,293.9	390.4
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>		<b>163,625.2</b>	<b>282,122.0</b>	<b>271,621.5</b>	<b>10,500.5</b>	<b>96.3</b>
	Ашигт малтмал, газрын тосны газар	156,858.9	233,875.6	237,332.7	-3,457.2	101.5
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		6,761.4	0.0	6,761.4	0.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	6,766.3	41,485.0	34,288.8	7,196.3	82.7
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>		<b>574.9</b>	<b>378,796.7</b>	<b>259,885.1</b>	<b>118,911.6</b>	<b>68.6</b>
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	206.5	420.0	420.0	0.0	100.0
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого		2,416.3	2,269.1	147.2	93.9
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	55,394.5	35,597.5	19,797.0	64.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	368.4	320,565.9	221,598.5	98,967.4	69.1
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн</b>		<b>65,760.4</b>	<b>752,113.2</b>	<b>658,235.1</b>	<b>93,878.1</b>	<b>87.5</b>

<b>Үйлдвэрийн сайд</b>						
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	-13,608.5	211,045.0	243,984.7	-32,939.7	115.6
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	16,037.6	43,966.5	38,477.8	5,488.7	87.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	63,331.3	497,101.7	375,772.6	121,329.1	75.6
<b>Эрүүл мэндийн сайд</b>		<b>159,188.0</b>	<b>1,027,396.0</b>	<b>927,771.9</b>	<b>99,624.1</b>	<b>90.3</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	140,560.7	863,618.5	816,104.2	47,514.3	94.5
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	777.6	50,041.6	6,063.2	43,978.3	12.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	17,849.7	113,735.9	105,604.5	8,131.4	92.9
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>		<b>4,703.6</b>	<b>66,696.3</b>	<b>69,506.5</b>	<b>-2,810.2</b>	<b>104.2</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,231.6	65,327.4	66,926.9	-1,599.5	102.4
	Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	471.9	1,369.0	2,579.6	-1,210.6	188.4
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>		<b>186.0</b>	<b>4,156.1</b>	<b>3,436.6</b>	<b>719.5</b>	<b>82.7</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	3,503.0	2,784.9	718.1	79.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	186.0	653.1	651.7	1.4	99.8
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b>		<b>6,918.7</b>	<b>47,737.8</b>	<b>42,902.1</b>	<b>4,835.8</b>	<b>89.9</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,737.9	24,804.6	16,256.0	8,548.6	65.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,180.8	22,933.2	26,646.0	-3,712.8	116.2
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>		<b>1,246.7</b>	<b>5,266.2</b>	<b>913.4</b>	<b>4,352.7</b>	<b>17.3</b>
	Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	859.6	1,169.0	913.4	255.5	78.1
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	387.2	4,097.2	0.0	4,097.2	0.0
<b>Батлан хамгаалахын сайд</b>		<b>38,156.4</b>	<b>248,796.5</b>	<b>227,998.3</b>	<b>20,798.2</b>	<b>91.6</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,543.1	23,205.5	22,760.9	444.6	98.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	33,613.3	225,591.0	205,237.4	20,353.6	91.0
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>		<b>34.9</b>	<b>264.6</b>	<b>804.9</b>	<b>-540.3</b>	<b>304.2</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	34.9	264.6	804.9	-540.3	304.2
<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>		<b>1,152.8</b>	<b>3,769.3</b>	<b>6,921.2</b>	<b>-3,151.8</b>	<b>183.6</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,152.8	3,769.3	6,921.2	-3,151.8	183.6
<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b>		<b>2.7</b>	<b>4,739.0</b>	<b>3,066.2</b>	<b>1,672.8</b>	<b>64.7</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	4,711.5	3,039.2	1,672.3	64.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2.7	27.5	27.1	0.4	98.4

Эх сурвалж: Сангийн яам



**3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл**

**Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,873.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 83.8 хувийг ашиглаж 1,434.6 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.**

Нэгдсэн төсвийн зарлагын 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/  
**Хүснэгт 4.** /тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,873.9	7,439.3	6,926.0	5,913.5	2,431.2	2,004.4	1,747.2	1,709.1
НИЙТ ЗАРЛАГА	8,479.7	7,223.9	6,570.2	5,713.5	2,392.9	1,989.0	1,747.2	1,709.1
УРСГАЛ ЗАРДАЛ	6,595.1	6,063.7	5,184.2	4,816.1	1,894.3	1,726.2	1,747.2	1,709.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,984.5	2,681.7	1,831.7	1,608.5	1,285.9	1,200.7	18.7	17.7
Зээлийн үйлчилгээний төлбөр	1,063.3	977.8	1,063.3	977.8	0.0	0.0	0.0	0.0
Татаас	260.5	218.1	618.1	610.6	77.5	69.7	103.2	76.2
Урсгал шилжүүлэг	2,286.8	2,186.1	1,671.0	1,619.3	530.9	455.8	1,625.3	1,615.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,884.6	1,160.2	1,386.0	897.4	498.6	262.8	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	394.1	215.4	355.8	200.0	38.3	15.4	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-2,826.0	-980.4	-2,568.4	-1,290.9	-299.3	129.5	41.8	181.0

Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 1,012.5 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 426.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 38.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улсын төсвийн нийт зардал 117.7 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн зардал 87.1 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин Орон нутгийн төсвийн зардал 25.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 3.8 хувь буюу 297.4 тэрбум төгрөгөөр буурахад эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 55.9 хувь буюу 273.2 тэрбум, хөрөнгийн зардал 17.5 хувь буюу 246.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь голлон нөлөөлжээ.

Харин урсгал зардал 222.1 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар нэмэгдсэн байна. Бараа, ажил үйлчилгээний зардал 4.2 хувь буюу 117.2 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч зээлийн үйлчилгээний төлбөр 287.9 тэрбум төгрөг буюу 41.7 хувиар, урсгал шилжүүлэг 17.4 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар, татаас 34.0 тэрбум төгрөгөөр буюу 18.5 хувиар тус тус өссөн нь урсгал зардал өсөхөд нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл  
 /Зардлын эдийн засгийн ангиллаар/

**Хүснэгт 5.** /тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Ху в ь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,736.7</b>	<b>8,873.9</b>	<b>7,439.3</b>	<b>83.8</b>	<b>1,434.6</b>
НИЙТ ЗАРЛАГА	7,248.1	8,479.7	7,223.9	85.2	1,255.8
УРСГАЛ ЗАРДАЛ	5,841.7	6,595.1	6,063.7	91.9	531.4
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,798.9</b>	<b>2,984.5</b>	<b>2,681.7</b>	<b>89.9</b>	<b>302.8</b>

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,564.6	1,649.8	1,588.6	96.3	61.1
Үндсэн цалин	1,384.1	1,345.7	1,315.6	97.8	30.1
Нэмэгдэл	75.3	180.5	163.6	90.6	17.0
Унаа хоолны хөнгөлөлт	30.4	36.9	33.3	90.3	3.6
Урамшуулал	40.3	46.6	40.5	86.8	6.1
Гэрээт ажлын хөлс	34.5	40.0	35.7	89.2	4.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143.3	151.8	145.2	95.7	6.6
Тэтгэврийн даатгал	143.3	94.3	89.9	95.4	4.4
Тэтгэмжийн даатгал	0.0	11.8	11.4	96.2	0.4
ҮОМШӨ-ний даатгал	0.0	10.8	10.4	96.6	0.4
Ажилгүйдлийн даатгал	0.0	2.6	2.5	96.3	0.1
Эрүүл мэндийн даатгал	0.0	32.2	30.9	96.0	1.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191.7	216.9	195.1	89.9	21.8
Гэрэл, цахилгаан	36.9	40.9	37.1	90.7	3.8
Түлш, халаалт	121.1	136.2	121.4	89.1	14.8
Цэвэр, бохир ус	18.1	21.3	19.0	89.2	2.3
Байрны түрээс	15.6	18.6	17.7	95.0	0.9
Хангамж, бараа материалын зардал	102.8	113.8	101.6	89.3	12.2
Бичиг хэрэг	7.9	9.5	8.5	89.5	1.0
Тээвэр, шатахуун	37.1	39.0	35.2	90.1	3.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10.2	11.3	9.5	83.9	1.8
Ном, хэвлэл	3.1	6.6	4.4	66.9	2.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36.6	38.6	36.2	94.0	2.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7.8	8.8	7.8	88.6	1.0
Нормативт зардал	223.9	231.2	211.9	91.7	19.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	103.2	109.7	101.0	92.1	8.6
Хоол, хүнс	90.6	92.6	85.8	92.6	6.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	30.1	28.9	25.1	86.9	3.8
Эд хогшил, урсгал засварын зардал	35.7	51.3	44.2	86.1	7.1
Багаж, техник, хэрэгсэл	9.3	15.7	12.6	80.4	3.1
Тавилга	3.6	2.5	1.8	74.2	0.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.5	1.1	0.7	61.4	0.4
Урсгал засвар	22.3	32.0	29.0	90.7	3.0
Томилолт, зочны зардал	16.2	22.0	17.2	78.2	4.8
Гадаад албан томилолт	4.5	7.8	6.2	78.9	1.7
Дотоод албан томилолт	9.5	11.8	9.0	75.7	2.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	2.2	2.4	2.1	88.7	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	277.1	384.0	290.2	75.6	93.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239.5	353.7	267.5	75.6	86.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.8	1.1	0.7	61.2	0.4
Даатгалын үйлчилгээ	7.6	9.0	9.2	101.6	-0.1
Тээврийн хэрэгслийн татвар	0.5	0.6	0.5	81.9	0.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.2	82.4	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3.8	6.9	4.3	62.2	2.6
Газрын төлбөр	0.8	1.2	0.9	77.9	0.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.6	1.6	1.0	66.7	0.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8.3	9.7	6.0	61.3	3.8
Бараа үйлчилгээний бусад зардал	387.1	315.5	232.9	73.8	82.6
Бараа үйлчилгээний бусад зардал	365.6	281.5	205.4	73.0	76.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21.4	33.9	27.4	80.9	6.5
<b>ХҮҮ</b>	<b>689.9</b>	<b>1,063.3</b>	<b>977.8</b>	<b>92.0</b>	<b>85.6</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	261.8	524.5	469.0	89.4	55.5
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	428.2	538.8	508.8	94.4	30.0
<b>ТАТААС</b>	<b>184.1</b>	<b>260.5</b>	<b>218.1</b>	<b>83.7</b>	<b>42.3</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	17.0	21.3	19.9	93.3	1.4



Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	167.1	239.1	198.2	82.9	40.9
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,168.7</b>	<b>2,286.8</b>	<b>2,186.1</b>	<b>95.6</b>	<b>100.7</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	60.7	19.7	16.4	83.2	3.3
Засгийн газрын дотоод шилжүүлэг	48.8	12.7	11.5	90.9	1.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	11.9	7.0	4.8	69.3	2.1
Бусад урсгал шилжүүлэг	2,108.0	2,267.1	2,169.7	95.7	97.4
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,403.5	1,444.4	1,444.1	100.0	0.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	452.2	507.2	480.3	94.7	26.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9.9	5.4	4.1	74.7	1.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133.8	162.5	119.6	73.6	43.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	21.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	79.1	76.4	62.3	81.5	14.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24.4	57.0	54.0	94.8	3.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5.0	14.1	5.4	38.5	8.7
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,406.4</b>	<b>1,884.6</b>	<b>1,160.2</b>	<b>61.6</b>	<b>724.5</b>
Барилга байгууламж	946.9	1,272.3	757.4	59.5	515.0
Их засвар	115.1	76.7	53.5	69.7	23.2
Тоног төхөөрөмж	43.3	113.6	54.4	47.9	59.2
Бусад хөрөнгө	100.5	386.9	272.3	70.4	114.6
Стратегийн нөөц хөрөнгө	2.4	35.0	22.6	64.6	12.4
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	198.3	0.0	0.0	-	0.0
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>488.6</b>	<b>394.1</b>	<b>215.4</b>	<b>54.7</b>	<b>178.7</b>
Эргэж төлөгдөх зээл	463.9	242.1	120.8	49.9	121.2
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	-	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	24.7	152.1	94.6	62.2	57.5


Эх сурвалж: Сангийн яам

**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 81.5 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.0 пунктээр өссөн байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 81.5 хувь буюу 6,063.7 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 44.2 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 16.1 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.6 хувийг татаас, 36.1 хувийг урсгал шилжүүлэг бүрдүүлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 222.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 287.9 тэрбум, татаас 34.0 тэрбум, урсгал шилжүүлэг 17.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



**Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд улсын төсвийн 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 856.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.**

Улсын төсвийн нийт зарлагын 22.2 хувийг Сангийн сайдын багц, 18.5 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 9.7 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 17.7 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.2 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 3.2 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, 8.7 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайд, 2.1 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, үлдэх 11.8 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

**Хүснэгт 6.**

*/сая төгрөг/*

Төсвийн ерөнхийлөн захирагч	2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	4,216.0	3,737.7	478.3	88.7
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	29,424.5	24,246.6	5,177.9	82.4
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	268,252.8	213,890.4	54,362.4	79.7
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	21,433.5	14,500.6	6,932.9	67.7
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	60,260.3	54,236.7	6,023.6	90.0
САНГИЙН САЙД	1,392,046.6	1,265,682.6	126,364.0	90.9
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	198,944.1	185,057.7	13,886.4	93.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	632,819.9	552,176.5	80,643.4	87.3
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,474.7	1,310.1	164.6	88.8
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3,795.4	3,080.4	715.0	81.2
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	42,838.6	41,216.2	1,622.4	96.2
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	24,655.4	23,685.9	969.5	96.1
ҮНДСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1,870.2	2,483.4	-613.2	132.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	8,836.0	8,024.9	811.1	90.8
ҮНДСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	7,683.1	6,300.0	1,383.1	82.0
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	2,334.5	2,301.4	33.1	98.6
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	692.6	674.1	18.5	97.3
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	543.2	478.7	64.5	88.1
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	105,800.9	88,600.6	17,200.3	83.7
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	15,690.2	15,257.6	432.6	97.2
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСНИЙ КОМИССЫН ДАРГА	736.5	678.9	57.7	92.2
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	9,282.7	8,490.8	792.0	91.5
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	62,049.6	53,076.7	8,972.9	85.5
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	427,593.9	356,098.6	71,495.3	83.3
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	82,250.9	46,972.5	35,278.4	57.1
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,165,679.6	1,054,410.6	111,269.0	90.5
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	637,990.5	494,655.2	143,335.3	77.5
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	26,991.3	16,620.7	10,370.6	61.6
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	157,888.2	120,153.2	37,735.0	76.1
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	124,859.2	44,111.5	80,747.7	35.3
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	1,051,262.3	1,011,315.4	39,946.9	96.2
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>6,570,197.3</b>	<b>5,713,526.0</b>	<b>856,671.3</b>	<b>87.0</b>

Эх сурвалж: Сангийн яам

#### 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2017 онд санхүүжүүлэх дүнгээр 602.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс эхний 11 сарын гүйцэтгэлээр 283.7 тэрбум төгрөг зарцуулж, төлөвлөгөөний биелэлт 47.1 хувьтай гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл  
/төсвийн ерөнхийлөн захирагчаар/

**Хүснэгт 7.**

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2017 оны эхний 11 сарын гүйцэтгэл			
		Төсөвт өртөг	Гүйцэт.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,688.0	1,688.0	1,634.4	53.6	96.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	8,100.0	2,778.0	753.2	2,024.8	27.1
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	45,243.4	7,055.1	5,673.7	1,381.4	80.4
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	17,253.7	5,763.3	1,947.6	3,815.7	33.8
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2,593.5	824.3	471.1	353.2	57.2
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	5,978.2	1,518.2	637.6	880.6	42.0
САНГИЙН САЙД	46,377.8	8,639.7	4,732.0	3,907.7	54.8
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	74,833.1	33,337.3	24,653.6	8,683.7	74.0
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	25,720.7	7,810.8	5,951.0	1,859.8	76.2
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	49,979.4	4,896.9	4,585.1	311.8	93.6
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	477,699.2	73,811.3	36,103.6	37,707.7	48.9
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	420,646.9	104,310.2	60,641.3	43,668.9	58.1
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	802,377.7	143,915.3	72,249.2	71,666.1	50.2
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	2,848.2	2,848.2	2,833.9	14.3	99.5
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	52,066.3	26,984.6	8,558.7	18,425.9	31.7
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	194,679.1	61,740.8	35,055.8	26,685.0	56.8
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	273,284.4	113,245.1	16,327.5	96,917.5	14.4
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	1,031.4	851.4	851.4	0.0	100.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	952.7	88.3	88.3	0.0	100.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>2,503,353.7</b>	<b>602,106.9</b>	<b>283,749.2</b>	<b>318,357.7</b>	<b>47.1</b>

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 177.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс эхний 11 сард 141.4 тэрбум төгрөг зарцуулж **79.5** хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн гүйцэтгэл  
/төсвийн ерөнхийлөн захирагчаар/

**Хүснэгт 8.**

/сая төгрөг/

	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР, ХҮЧИН ЧАДАЛ, БАЙРШИЛ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2017 онд санхүүжих дүн	Эхний 11 сарын гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>	<b>354,428.1</b>	<b>177,741.6</b>	<b>141,383.1</b>	<b>36,358.5</b>	<b>79.5</b>
<b>I.1</b>	<b>Үндэсний хөгжлийн газар</b>	<b>354,428.1</b>	<b>177,741.6</b>	<b>141,383.1</b>	<b>36,358.5</b>	<b>79.5</b>
	<i>Концессын төслийн эргэн төлөлт</i>	<i>354,428.1</i>	<i>177,741.6</i>	<i>141,383.1</i>	<i>36,358.5</i>	<i>79.5</i>
<b>I.1.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>	<b>354,428.1</b>	<b>177,741.6</b>	<b>141,383.1</b>	<b>36,358.5</b>	<b>79.5</b>
	<i>Шилжих</i>	<i>350,351.9</i>	<i>173,665.4</i>	<i>141,383.1</i>	<i>32,282.3</i>	<i>81.4</i>
<b>I.1.1.1</b>	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	117,042.0	52,304.7	51,738.5	566.2	98.9
<b>I.1.1.2</b>	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	176,405.4	78,825.3	77,975.7	849.6	98.9
<b>I.1.1.3</b>	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14	10,787.0	10,787.0	2,900.0	7,887.0	26.9


	дүгээр сургууль/					
I.1.1.4	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	14,884.5	5,581.7		5,581.7	0.0
I.1.1.5	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/	10,736.3	7,515.4		7,515.4	0.0
I.1.1.6	Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 32 дугаар сургууль/	5,800.0	5,800.0	2,900.0	2,900.0	50.0
I.1.1.7	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/	1,386.6	796.4	766.0	30.4	96.2
I.1.1.8	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	2,050.3	2,050.0	2,050.0	-	100.0
I.1.1.9	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2,357.9	1,687.9	1,687.9	-	100.0
I.1.1.10	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	1,949.9	1,365.0	1,365.0	-	100.0
I.1.1.11	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	6,952.0	6,952.0		6,952.0	0.0
	<i>Шинэ</i>	<b>4,076.2</b>	<b>4,076.2</b>	-	<b>4,076.2</b>	<b>0.0</b>
I.1.1.12	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 6 дүгээр цэцэрлэг/	1,154.0	1,154.0		1,154.0	0.0
I.1.1.13	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, Баян-Ойт 1 дүгээр цэцэрлэг/	1,154.0	1,154.0		1,154.0	0.0
I.1.1.14	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Баянхонгор, Богд сум	738.2	738.2		738.2	0.0
I.1.1.15	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	1,029.9	1,029.9		1,029.9	0.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>354,428.1</b>	<b>177,741.6</b>	<b>141,383.1</b>	<b>36,358.5</b>	<b>79.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

## 5. Нийгмийн даатгалын сан

### Нийгмийн даатгалын сангийн орлого:

График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого /тэрбум төгрөгөөр/




Нийгмийн даатгалын санд 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр нийт 1,890.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөсөн дүнгээс 5.7 хувь буюу 101.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

НДС-ийн нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 263.5 тэрбум төгрөг буюу 16.2 хувиар өссөн байна. Тус санд улсын төсвөөс 538.3 тэрбум төгрөгийн татаас олгожээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын санд 1,313.7 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын санд 97.4 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 125.8 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын санд 38.3 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 325.5 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

**Нийгмийн даатгалын сангийн зарлага:**

**График 7.** Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /тэрбум төгрөгөөр/




2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн нийт зардалд 1,747.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бусад зардалд нийт 1,709.1 тэрбум төгрөгийг зарцуулж, 97.8 хувийн гүйцэтгэлтэй гарч, 38.0 тэрбум төгрөг дутуу зарцуулагдсан байна.

Тус сангийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 87.1 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 11.4 хувь буюу 5.4 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 7.6 хувь буюу 2.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан ч тэтгэвэрийн даатгалын сангийн зарлага 7.2 хувь буюу 87.5 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 4.9 хувь буюу 4.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2.2 хувь буюу 5.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь НДС-ийн нийт зарлага өсөхөд нөлөөлжээ.

**График 8.** Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /хувиар/



2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр тэтгэвэрийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 1,295.9 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 90.0 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир

дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 41.7 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид болон бусад зардалд 32.4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгийн тусламж, үйлчилгээ, рашаан сувилал, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад зардалд 251.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**6. Орон нутгийн төсөв**

**Орон нутгийн төсвийн зарлага 426.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.**

2017 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 2,133.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 0.09 хувь буюу 2.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн, нийт зарлага 2,004.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 17.6 хувь буюу 426.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 11.5 хувь буюу 220.9 тэрбум төгрөгөөр өсч, мөн нийт зарлага 1.2 хувь буюу 25.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 46.0 хувийг орон нутгийн төсвийн орлого, 5.9 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 45.6 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 2.5 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 125.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.



Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

**Хүснэгт 9.**

/сая төгрөг/

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	11,138.7	11,138.7	100	35,470.4	35,470.4	100	1,987.2	1,987.2	100
Баян-Өлгий	10,125.6	10,125.6	100	44,792.6	44,792.6	100	1,654.4	1,654.4	100
Баянхонгор	10,570.8	10,570.8	100	35,220.5	35,220.5	100	2,163.3	2,163.3	100
Булган	0.0	0.0	-	26,979.2	26,979.2	100	1,745.0	1,745.0	100
Говьсүмбэр	0.0	0.0	-	7,324.6	7,324.6	100	1,178.1	1,178.1	100
Говь-Алтай	7,810.8	7,810.8	100	30,365.2	30,365.2	100	2,185.0	2,185.0	100
Дархан-Уул	0.0	0.0	-	31,575.4	31,575.4	100	1,773.3	1,773.3	100
Дорноговь	0.0	0.0	-	26,468.2	26,468.2	100	2,307.0	2,307.0	100
Дорнод	2,553.5	2,553.5	100	27,542.5	27,542.5	100	2,084.1	2,084.1	100
Дундговь	5,443.2	5,443.2	100	21,803.7	21,753.7	100	1,846.8	1,846.8	100
Завхан	9,028.6	9,028.6	100	34,739.6	34,739.6	100	1,708.7	1,708.7	100
Орхон	0.0	0.0	-	30,315.4	30,315.4	100	1,941.3	1,941.3	100
Өвөрхангай	10,805.4	10,805.4	100	41,494.9	41,494.9	100	2,253.9	2,253.9	100
Өмнөговь	0.0	0.0	-	26,063.4	26,063.4	100	3,190.3	3,190.3	100
Сүхбаатар	4,927.5	4,927.5	100	26,284.5	26,284.5	100	1,554.8	1,554.8	100
Сэлэнгэ	3,323.0	3,323.0	100	42,796.5	42,796.5	100	2,139.6	2,139.6	100
Төв	7,396.7	7,396.7	100	39,156.6	39,156.6	100	1,808.2	1,808.2	100
Увс	10,614.9	10,614.9	100	37,283.8	37,283.8	100	1,709.8	1,709.8	100
Улаанбаатар	0.0	0.0	-	288,374.1	288,374.1	100	11,822.6	11,822.6	100
Ховд	7,447.5	7,447.5	100	36,556.1	36,556.1	100	1,778.3	1,778.3	100
Хөвсгөл	16,602.0	16,602.0	100	51,094.1	51,094.1	100	2,186.4	2,186.4	100
Хэнтий	8,039.1	8,039.1	100	31,538.8	31,538.8	100	1,995.4	1,995.4	100
<b>ДҮН</b>	<b>125,827.2</b>	<b>125,827.2</b>	<b>100</b>	<b>973,240.3</b>	<b>973,190.3</b>	<b>99.9</b>	<b>53,013.5</b>	<b>53,013.5</b>	<b>100</b>

Эх сурвалж: Сангийн Яам



Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 973.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгосон байна.

2017 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр аймгуудын орон нутгийн хөгжлийн санд 53.0 тэрбум төгрөгийг шилжүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнд 100.0 хувь хүрч биелжээ.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн зарим аймгуудыг авч үзэхэд Өмнөговь аймаг 7.7 тэрбум, Төв аймаг 3.6 тэрбум, Хэнтий аймаг 2.1 тэрбум, Сэлэнгэ аймаг 1.8 тэрбум, Хөвсгөл аймаг 1.7 тэрбум, Орхон аймаг 0.5 тэрбум төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

## ДУГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны эхний 11 сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

**Төсвийн орлогын хувьд:** 2017 оны эхний 11 сарын байдлаар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл сар бүрийн төлөвлөсөн дүнгээс давж биелсэн, мөн өмнөх оны мөн үеэс өссөн зэрэг үзүүлэлттэй гарч, төсөвт эерэг нөлөөлөл бий болж байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 1 дүгээр сард 105.3 хувь, 2 дугаар сард 100.0 хувь, 3 дугаар сард 103.1 хувь, 4 сард 104.1 хувь, 5 дугаар сард 103.1 хувь, 6 дугаар сард 104.7 хувь, 7 дугаар сард 108.1 хувь, 8 дугаар сард 109.3 хувь, 9 дүгээр сард 109.6 хувь, 10 дугаар сард 114.1 хувийн биелэлттэй байсан бол энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 106.8 хувийн биелэлттэй гарсан байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс өсөлттэй гарч, тухайлбал: 1 дүгээр сард 31.4 хувь, 2 дугаар сард 35.9 хувь, 3 дугаар сард 37.3 хувь, 4 сард 26.5 хувь, 5 дугаар сард 27.9 хувь, 6 дугаар сард 28.9 хувь, 7 дугаар сард 28.3 хувь, 8 дугаар сард 25.4 хувь, 9 дүгээр сард 25.5 хувь буюу 1,022.4 тэрбум төгрөгөөр, 10 дугаар сард 29.8 хувь буюу 1,341.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол 11 дүгээр сарын байдлаар 27.7 хувь буюу 1,399.5 тэрбум төгрөгийн өсөлттэй байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт ихээхэн нөлөөлсөн. Татварын орлого 2017 он гарснаас хойш сар бүр давж биелэгдсэн байна. Тухайлбал, 2017 оны 1 дүгээр сард 0.8 хувиар буюу 2.9 тэрбум төгрөгөөр давсан байсан бол тогтвортой өсч, 3 дугаар улирлын байдлаар 17.4 хувь буюу 651.3 тэрбум төгрөг, 10 дугаар сард 21.6 хувь буюу 901.4 тэрбум төгрөгөөр, 11 дүгээр сарын байдлаар 8.9 хувь буюу 461.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ. Татварын орлогын хувьд тайлант хугацааны туршид бүх төрлийн албан татвар төлөвлөсөн хэмжээндээ хүрч биелэлттэй гарсан байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 1 дүгээр сард 31.6 хувиар давж биелсэн хэдий ч 9 дүгээр сард 24.6 хувь буюу 209.8 тэрбум төгрөгөөр, 10 дугаар сард 19.2 хувь буюу 178.8 тэрбум төгрөгөөр, 11 дүгээр сард 5.7 хувь буюу 50.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Үүнд: гадаад хандив тусламжийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогын тасалдал голлон нөлөөлжээ.

**Төсвийн нийт зарлагын хувьд:** Нэгдсэн төсвийн нийт зарлага энэ оны эхний 11 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 16.2 хувь буюу 1,434.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна. Үүнд:

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 1-11 дүгээр сард 16.2-33.5 хувиар дутуу зарцуулагджээ.
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 1-11 дүгээр саруудад 74.2-87.0 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөснөөс дутуу зарцуулагдаж ирсэн байна. 10 дугаар сард 710.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 87.5 хувийн гүйцэтгэлтэй байсан бол эхний 11 сарын байдлаар төлөвлөснөөс 856.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 87.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд эхний 11 сарын байдлаар 283.7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж 47.1 хувийн гүйцэтгэлтэй, мөн “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид 141.4 тэрбум төгрөг зарцуулж 79.5 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

- 000 -